

Гоо зүйн талаарх Гегелийн үзэл

Доктор Б.Дэлгэрмаа.

Түлхүүр үг: сайхан, урлаг, идеал, туйлын санаа, символик үе, античный үе, романтик үе, оюун ухаан, диалектик, зөрчил, урлагийн төрөл зүйл.

Германы сонгодог философийн хамгийн нэрт төлөөлөгч Гегель /1770-1831/ философийн ерөнхий системийнхээ дотор гоо зүйн үзэл онолыг боловсруулж байсан юм. Гегелийн гоо зүйн үзэл нь сайхны тухай асуудал, урлагийн тухай ойлголт, урлагийн түүхэн хэлбэрүүд, урлагийн төрөл зүйлийн ангилал гэсэн хэсгүүдээс бүрэлдэнэ.

Гегель сайхны тухай асуудлыг судлахдаа түүхэн ба логик аргыг гол арга зүйгээ болгон ашигласан гэж хэлж болно. Тэрээр эртний Грекийн урлагийг хүн төрөлхтний урлагийн хөгжлийн оргил үе гэж үзэж байсан бөгөөд чухам тэр урлагаас л сайхны тухай асуудлыг гаргаж тайлбарлажээ. Гегель гоо зүйн ойлголтуудыг, тэр дундаа сайхны тухай ойлголтыг хөдөлгөөнгүй бүдүүвч схем гэж үзсэнгүй, харин гоо сайхны болоод уран сайхны танин мэдэхүй болон практиктай холбоотой байнга хувьсан өөрчлөгдөж байдаг гэж үзэж байлаа.

Сайхны талаар Гегелийн дэвшүүлсэн оновчтой бөгөөд нэн дэвшилттэй үзэл нь сайхныг аксиологийн шинжтэй холбож үзсэн явдал мөн. Тэр үзэхдээ, байгаль дээр сайхан биеэ даан оршиж байна гэдэг бол туйлын эргэлзээтэй зүйл мөн. Учир нь түүнийг шалгах шалгуур, батлах нотолгоо байхгүй. Цэцэг хэзээ ч өөрийгөө сайхан гэж үнэлээгүй. Яагаад гэвэл, түүнд оюун ухааны мэдрэмж байхгүй. Харин хүн бол оюун ухааны мэдрэмжээрээ тухайн үзэгдлүүдэд ямагт үнэлэлт өгч байдаг болохоор сайхан нь эцсийн дүнд оюун ухаанд (үүнийг хүний мэдлэгт оршиж байдаг гэсэн санаагаар ойлгож болно) байдаг хэмээн үзжээ. Энд сайхан гэдэг нь хүн бодит байдлын юмс үзэгдэлд оршиж буй тодорхой шинж чанарыг танин мэдсэнийхээ (өөрөөр хэлбэл, оюун ухаандаа хүлээж авсныхаа) үндсэн дээр хүнээс түүнд өгч байгаа үнэлгээ юм гэдэг онолын нэн чухал санаа илэрхийлэгдэж байна. Орчин үеийн гоо зүйн онол Гегелийн гаргаж тавьсан энэ үзэл баримтлалын үүднээс сайхны асуудлыг авч үзэж байгаа билээ. Энэ бол Гегелийн гоо сайхны үзлийн гол ололт, гоо зүйн шинжлэх ухаанд түүний оруулсан гавъяа мөн.

Гегель сэтгэлгээний өндөр төвшингөөс философи, гоо зүйн онолын асуудлыг авч үзсэн юм. Үүнийг философи, урлаг, шашны хамаарлын талаархи үзлээс нь тодорхой харж болно. Гегель философи, урлаг, шашин гурав бол нэг эх үүсвэртэй, тэр нь оюун ухаан юм гэж үзсэн байна. "Оюун ухаан өөрөө өөрийгөө сэтгэх юм бол философи болно, оюун ухаан өөрөө өөрийгөө шүтэх юм бол шашин болно, оюун ухаан өөрөө өөрийгөө төсөөлөх юм бол урлаг болно"¹ гэж Гегель үзэж байлаа. Энэ хандлагаараа ч үнэн, сайн, сайхан гэсэн ойлголтуудыг авч үзэж тайлбарласан байна. Үнэн нь зайлшгүйтэй холбоотой байдаг бол, сайн нь эрх чөлөөтэй холбоотой оршин байна. Харин сайхан бол зайлшгүй ба эрх чөлөө хоёрын синтезийн байдалтай оршдог гэсэн нь уг асуудлыг өөрийн алдарт гурвалынхаа системийн үүднээс авч үзжээ гэж хэлж болох мэт санагдана. Энэ мэтчилэн сайхны талаархи Гегелийн үзэлд онол-арга зүйн онц чухал ач холбогдолтой санаа дэвшүүлэгдэж гарсан нь түүнийг агуу их сэтгэгч, онолч байсныг бидэнд батлан харуулж байна.

Гегель гоо зүйн бас нэг үндсэн ойлголтууд болох эмгэнэлт ба инээдэмт зүйлийн асуудлыг авч үзсэн юм. Тэрээр эмгэнэлт ба инээдэмт зүйлийн

¹ Гегель. Г.В.Ф. Эстетика. В 4-х томах. Т.1. М., 1968. с.109.

ойлголтыг хүн төрөлхтний түүхийн янз бүрийн шатан дахь зөрчлүүдийг тусгасан ойлголт юм гэж үзжээ. Эмгэнэлт ба инээдэмт зүйлийн тухай түүний үзэл, эртний Грекчүүдийн, ялангуяа Аристотелийн үзлээс нэлээд уламжлалтай гэж хэлж болно. Гэхдээ тэрээр Грекчүүдийн үзлийг шууд хуулбарлаагүй, харин диалектикийн гол агуулга болох зөрчлийн тухай үзэлтэйгээ холбон авч үзсэн юм. Нийгмийн өв тэгш зохион байгуулалт эвдэгдэж зөрчил хурцдах явдал нь эмгэнэлт явдал ба инээдэмт зүйл гарах нөхцөлийг бий болгодог хэмээн үзсэн нь онолын хувьд зөв баримтлал байлаа. Энэ санаагаа тэр цааш нь гүнзгийрүүлэн тайлбарласангүй орхисон байна. Гэвч арга зүйн үүднээс түүний үзэлд чухал санаа агуулагдаж байна гэж хэлэхэд буруудах зүйл огт үгүй.

Гегелийн хувьд оршин байгаа бүхний үндэс нь ямар нэгэн хувь хүний бус харин туйлын оюун санаа байдаг бөгөөд чухам тэр оюун санаа л байгаль, нийгмийн бүх үзэгдэл, үйл явцын эхлэл болдог. Энэ үзлээрээ тэр мөн гоо сайхны асуудалд ч хандсан. Түүний үзэж байгаагаар гоо сайхны бүхий л илрэлүүд нь туйлын оюун санааны тодорхой шатны биелэлүүд болж байдаг. Энд гоо сайхны үзэл дэх түүний философийн гол шугам илэрч байна.

Гегель зүй зохист чанарыг өв тэгш зохицол гэдэг ойлголттой холбон авч үзээд нийгмийн хамгийн зүй зохист чанар нь эртний Грекийн нийгмийн байгуулал байгаа юм. Учир нь Грекийн нийгэм бол бүтэц зохион байгуулалтаараа сайхан ба зөв хэм хэмжээний биелэл байсан гэж тэмдэглэсэн байна. Тэгэхлээр Гегель зүй зохист чанарыг сайхан, зөв хэм хэмжээ, өв тэгш байдал зэрэг бодит байдлын чанаруудыг үнэлэх үнэлэмжтэй холбон авч үзсэн гэж хэлж болно. Үүнээс үзвэл, зүй зохист чанарын талаархи Гегелийн үзэл бусад төлөөлөгчдөөсөө илүү гүнзгий үндэслэлтэй байсан нь харагдаж байна.

Гегель урлаг бол идеалын илрэл юм гэж тодорхойлжээ. Идеал гэдэг ойлголт нь абсолютыг тэмдэглэдэг бөгөөд урлагт илэрч гардаг юм гээд, Гегель урлагийн үндсэн зорилго бол үнэнийг мэдрэхүйн хэлбэрт нээх явдал юм гэж үзсэн байна. Гегель оюун санаа өөрөө өөрийгөө нээх төгс хэлбэр нь философи, төгс бус хэлбэр нь урлаг гэж үзжээ. Энэ нь урлагийн танин мэдэхүйн үүргийн онцлогийг тэмдэглэсэн хэрэг мөн. Тэрээр урлагаар хүн ашиг олох, урлагаар ёс суртахууны хүмүүжил олгох зэрэг нь урлагийн гол зорилго биш гэж үзжээ.

Урлагийн хөгжлийн талаар Гегелийн дэвшүүлсэн санаа нэлээд өвөрмөц онцлогтой юм. Тэрээр, урлагийн хөгжил бол урлагийн тодорхой үеүд нэг нь нөгөөгөө халж солих явдлаар илэрч гарна гэж үзээд, хүн төрөлхтний урлагийн хөгжлийг гурван үед хуваажээ. Үүнд:

1. Символик үе
2. Античный үе
3. Романтик үе

Символик үе гэдэгт тэр голдуу Дорно дахины урлагийг хамааруулж авч үзсэн. Символик үе дараа нь Античный үеэр солигджээ. Энэ үеийг урлагийн хөгжлийн сонгодог үе гэж нэрлэсэн байна. Энд эртний Грекийн урлаг хамаарна. Сонгодог үеийн дараа романтик үе гарч ирсэн байна. Энэ үеийн онцлог нь урлаг мэдрэхүйн хэлбэрээс чөлөөлөгдөж, сэтгэхүйн хэлбэрт илүү их шилжин орж байгаа юм гэжээ. Романтик үеийн урлаг бол уран сайхны чин эрмэлзлэлээ илэрхийлэх арга барилын хувьд их өөрчлөгдсөн. Үүнтэй холбоотойгоор урлагаас нийгэмд гүйцэтгэх үүрэг багасч байна. Энэ бол урлаг үеэ өнгөрөөж байгаагийн илрэл юм гэжээ. Урлаг дахь санаа, түүний илрэх хэлбэр хоёр бүрэн зохицож чадсан үе бол сонгодог үе юм. Тиймээс ч энэ үе нь хүн төрөлхтний уран сайхны хөгжлийн оргил нь болж байна. Гэвч матери, оюун санаа хоёрын энэхүү зохицол удаан хадгалагдаагүй юм. Хөгжлийн дараагийн шат болох романтик урлаг гарч ирсэн боловч түүнд агуулга хэлбэр хоёрын тэнцвэрт харьцаа эвдэгдсэн байна гэж Гегель үзсэн.

Урлагийн хөгжлийн нэг үе нөгөө үеэр солигдох явдал бол тооны өөрчлөлт биш, чанарын өөрчлөлт юм. Энэ нь тасралт, үсрэлт, аажим шилжилт гэсэн хэлбэрээр явагдана. Энд Гегелийн диалектик санаа илэрч байна. Гегель

урлагийн төрөл зүйлийг түүхэн тодорхой үеүдтэй холбож авч үзсэн. Жишээлбэл, "Гомерын дуулал". Энэ бол зөвхөн эртний Грекийн баатарлаг үетэй холбоотой. Энэ нь өнөөгийн нийгэмд гарч ирэхгүй гэж үзсэн байна.

Гегель урлагийн төрөл зүйлүүдийн онцлогийг гаргаж тайлбарлажээ. Уран барилга бол символик үеийн хамгийн анхны урлаг. Уран барилгад материал нь ямагт санаагаа давамгайлж байдаг. Уран барилгад ашиглагддаг материал нь органик бус, байгалиас авсан зүйлүүд байдаг юм. Урлагийн нэгэн төрөл болох уран баримал гэдэг бол хүний чөлөөт оюун санаа хүний биеийн хэлбэрт биежсэнийг хэлнэ гэж Гегель үзжээ. Уран барималд оюун санаа түүнийг илэрхийлдэг физик хэлбэртэйгээ нэгдэж байдаг. Тийм учраас энэ бол нэлээд нарийн хөгжсөн урлаг. Гэвч оюун санааг илэрхийлдэг чухал зүйл болох нүдний харц, сэтгэл хөдлөл, мэдрэмж гэх мэт зүйл уран барималд сайн дүрслэгддэггүй. Эдгээр нь уран зураг, хөгжим, яруу найраг зэрэг романтик урлагт илүү тод илэрхийлэгдэнэ. Өөрөөр хэлбэл, урлагийн эдгээр төрлүүдэд оюун санаа илүү их давамгайлдаг. Романтик урлагийн төрлүүд дотроос уран барималд нэлээд ойртож очиж байгаа нь уран зураг юм. Уран зургийн хэрэгсэл нь байгалийн болхи бүдүүлэг материаллаг субстрат болох чулуу, мод гэх мэт зүйлүүд биш, харин өнгө, гэрэл, сүүдэр, гадаргуу гэсэн нарийн зүйлс байдаг. Үүний тусламжтайгаар уран зураг бүтээгдэнэ. Иймээс уран зураг бол мэдрэхүйн материаллаг биетүүдээс чөлөөтэй байдаг. Үүгээрээ ихээхэн давуутай юм. Уран зураг нь материаллаг биетийн орон зай эзлэх чанараас чөлөөлөгддөг бөгөөд зөвхөн хавтгайн хэмжээгээр хязгаарлагдана. Товчоор хэлбэл, уран зураг нь хоёр хэмжээст хавтгай дээрх дүрслэлээр хязгаарлагдаж байдаг. Тийм учраас уран зураг бол мэдрэхүйн бүх хэлбэрийг илэрхийлж чадна. Үүнд, сэтгэл санааны байдал, мөн үйлдлүүдийг, бүхэл бүтэн драмын хөдөлгөөнийг ч дүрсэлнэ. Гегель ийнхүү уран зургийн онцлогийг нэлээд оновчтой гаргаж өгсөн. Урлагийн романтик төрлийн нэг бол хөгжим юм. Хөгжим бол өөрийн дүр дүрслэлийг бүтээхдээ орон зайн хэмжээсүүдийг ашигладаггүй. Хөгжмийн үндсэн элемент нь дуу авиа байдаг. Хөгжим гэдэг бол дүр дүрслэлийн орон зайн хэмжээст, биш, цаг хугацаанд бүтээгддэг. Хөгжим нь мэдрэхүйг шаардахаасаа илүү сэтгэхүйг их шаарддаг. Ингэхдээ мэдрэхүйг бүрэн үгүйсгэдэггүй. Хөгжимд сонсгол чухал байдаг билээ. Хөгжмийн дүр нь шууд өгөгддөггүй, харин сэтгэхүйд өвөрмөц байдлаар үүсдэг онцлогтой гэж Гегель үзжээ.

Эцэст нь дүгнэж үзэхэд, Гегель гоо зүйн үзлээ боловсруулахдаа түүхэн ба логик арга, диалектик арга зүйг үндэслэлээ болгожээ. Гегель гоо зүйн үндсэн асуудал болох сайхны тухай асуудлыг хүний үнэлэмжтэй холбож тайлбарласан байна. Тэрээр урлагийн гол зорилго бол үнэнийг мэдрэхүйн хэлбэрт нээх явдал мөн гэж үзсэн нь урлагийн танин мэдэхүйн үүргийг онцолж байсныг харуулж байн

Резюме:

Теоретическое наследие Г.В.Ф.Гегеля стало своеобразным итогом развития немецкой классической эстетики. Философу удалось не только обобщить и систематизировать наиболее существенные идеи своих предшественников, но и ввести в рассмотрение эстетические проблем историзм и диалектику. "Эстетика" Гегеля состоит из введения, учения о прекрасном или идеале, учения о трёх формах существования искусства и теории отдельных его видов.

Ном зүй:

1. Ж.Төмөрбаатар. Гоо зүйн үндсэн категориуд. УБ., 2000
2. Л.Г.Бергер. Эпистемология искусства. М., 1997
3. Гегель. Г.В.Ф. Эстетика. М., 1968

4. К.Э.Гилберт, Г. Кун. История эстетики. СПб., 2000
5. О.А.Кривцун. Эстетика. М., 1998
6. М.Ф.Овсянников. История эстетической мысли. М., 1984
7. А.Г. Спиркин. Философия. М., 1999
8. Е.Л.Фейнберг. Кибернетика, логика, искусство. М., 1981
9. Эстетика. /учебник. под редакцией А.А.Радугина/. М., 1998
10. Art and its Significance.(edited by Stephen David Ross). New York., 1996
11. Colin Lyas. Aesthetics. New York., 1997
12. Hegel. Introductory lectures on Aesthetics. London., 1993
13. Postmodernism-Philosophy and the Arts. /edited by Hugh J. Silverman/. New York. 1990
14. The concise encyclopedia of Western philosophy and philosophers. /edited by J.O.Urmson and Jonathen Ree. New York., . 1996
15. What is philosophy. New-York.,1996